



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

2024 оны 12-р сарын 18-ны өдөр

№ 10

Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

МУССХ-ны “Мөнгөн урамшуулал олгох журам”-ыг
батлах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурал нь Холбооны дүрмийн 7.6-т Холбооны гишүүн нь “Үр бүтээлтэй ажиллаж, спортын өндөр амжилт гаргасны төлөө материалын болон сэтгэл санаа, нэр хүндийн урамшуулал хүртэх эрхтэй” гэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

- Холбооны “Мөнгөн урамшуулал олгох журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
- Журмыг Холбооны бүх гишүүдэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллахыг ЕНБД М.Энхбаатарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Батсайхан

П.БАТСАЙХАН



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ

МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГҮНДЭСЛЭЛ

- Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагчдыг урамшуулан дэмжих, тэдний нийгмийн асуудлыг зохих түвшинд шийдвэрлэж амжилт гаргах нөхцлийг бүрдүүлэх нь Монголын усан спорт сонирхогчдын холбоо (цаашид "Холбоо" гэх) үүрэг юм.
- Журам Холбооны гишүүн тамирчдын амжилтыг үнэлэх, урамшуулах, усан спортыг хөгжүүлэх зорилгоор мөнгөн урамшуулал олгох нөхцөл, журмыг тодорхойлоход оршино.
- Журам нь амжилтын зэрэглэлээс хамаарч улсын болон олон улсын тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн тамирчид, дасгалжуулагчдад хамаарна.
- Мөнгөн урамшууллыг тухайн амжилтад Улсаас олгох урамшуулал байгаа эсэхээс үл хамааран олгоно.
- Мөнгөн урамшууллыг олгоходоо ХАОТ-ын тухай хуульд заасан татварыг суутган тооцож олгоно.
- Журмыг Холбооны Удирдах зөвлөл баталж, хэрэгжилтэнд хяналт тавина.

Хоёр. ТЭМЦЭЭНИЙ МӨНГӨН ШАГНАЛ

- Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний Хувийн гараатай уралдааны шагналт байранд шалгарсан тамирчинд олгох мөнгөн урамшуулал;

	Тамирчин
Алтан медаль	100,000 төг
Мөнгөн медаль	60,000 төг
Хүрэл медаль	40,000 төг

- Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний Буухиа уралдааны шагналт байранд шалгарсан багт олгох мөнгөн урамшуулал. Нийт шагналын дүнг багийн гишүүдийн тоонд харьцуулан хуваарилна.

	Баг
Алтан медаль	200,000 төг
Мөнгөн медаль	120,000 төг
Хүрэл медаль	80,000 төг

2024 оны 12 сарын 18-ны өдрийн Удирдах зөвлөлийн

№ 10 тоот Тогтололын хавсралт



2.3 Ази тивийн залуучуудын болон насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээн, Азийн наадам, Дэлхийн оюутны наадмын шагналт байранд шалгарсан тамирчин болон түүний дасгалжуулагчдад олгох мөнгөн урамшуулал:

	Тамирчин	Дасгалжуулагч	Анхны дасгалжуулагч
Алтан медаль	2,000,000 төг	1,000,000 төг	500,000 төг
Мөнгөн медаль	1,500,000 төг	750,000 төг	350,000 төг
Хүрэл медаль	1,000,000 төг	500,000 төг	250,000 төг

2.4 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Дэлхийн цомын тэмцээний шагналт байранд шалгарсан тамирчин болон түүний дасгалжуулагчдад олгох мөнгөн урамшуулал:

	Тамирчин	Дасгалжуулагч	Анхны дасгалжуулагч
Алтан медаль	5,000,000	2,500,000	1,250,000
Мөнгөн медаль	3,500,000	1,750,000	850,000
Хүрэл медаль	2,000,000	1,000,000	500,000

2.5 Олимпийн наадам, залуучуудын олимп болон паралимпийн наадмын шагналт байранд шалгарсан тамирчин болон түүний дасгалжуулагчдад олгох мөнгөн урамшуулал:

	Тамирчин	Дасгалжуулагч	Анхны дасгалжуулагч
Алтан медаль	10,000,000	5,000,000	2,500,000
Мөнгөн медаль	7,000,000	3,500,000	1,750,000
Хүрэл медаль	5,000,000	2,500,000	1,250,000

2.6 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин:

В стандарт цагийг шинээр биелүүлсэн зайд төрөл тус бүрт зөвхөн нэг удаа – 1,000,000 төг

А стандарт цагийг шинээр биелүүлсэн зайд төрөл тус бүрт зөвхөн нэг удаа – 2,000,000 төг

2.7 Олимпийн наадамд оролцох тамирчин:

В стандарт цагийг биелүүлсэн зайд төрөл тус бүрт зөвхөн нэг удаа – 2,000,000 төг

А стандарт цагийг биелүүлсэн зайд төрөл тус бүрт зөвхөн нэг удаа – 3,000,000 төг

Гурав. РЕКОРД АМЖИЛТ

3.1 Насанд хүрэгчдийн улсын Рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тамирчинд, рекорд тогтоосон төрөл, зайд тус бүрт 100,000 төгрөгийн мөнгөн шагнал олгоно.

3.2 Тивийн болон тивийн наадмын рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тамирчинд, рекорд тогтоосон төрөл, зайд тус бүрт 1,000,000 төгрөгийн мөнгөн шагнал олгоно.



3.3 Дэлхийн болон Олимпийн наадмын рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тамирчинд, рекорд амжилт тогтоосон төрөл, зайд бүрт нь 3,000,000 төгрөгийн мөнгөн шагнал олгоно.

3.4 Рекорд амжилт тогтоосон тамирчдын мөнгөн шагналыг МУССХ-ны Ерөнхийлөгч ивээн тэтгэж олгоно.

Дөрөв. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА,

4.1. Урамшуулал хамрагдахын тулд шаардлагатай тохиолдолд дараах баримтыг бүрдүүлнэ.

4.1.1. Тэмцээний протокол, диплом эсвэл медалийн хуулбар.

4.1.2. Тухайн тэмцээний албан ёсны зохион байгуулагчийн баталгаа.

4.1.3. Иргэний үнэмлэхний хуулбар.

4.2. Мөнгөн урамшуулал олгох хүсэлтийг тамирчин эсвэл түүний багш, дасгалжуулагч нь мөнгөн урамшуулал хүссэн албан хүсэлтийг Холбооны гүйцэтгэх удирдлагад гаргана.

4.3 Насанд хүрэгчдийн УАШТ-ний мөнгөн шагналаас бусад мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг жилд нэг удаа Холбооны Гүйцэтгэх удирдлага Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.4 Мөнгөн урамшууллыг зөвхөн тамирчны нэр дээр бүртгэлтэй банкны дансанд бэлэн бусаар шилжүүлж гүйцэтгэнэ.

4.5 Зохих шаардлага хангагүй мэдээлэл ирүүлсэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл урамшуулал олгохыг түр тутгэлзүүлнэ.

Тав. БУСАД

5.1. Холбооны мөнгөн шагналын журамд Мастерсын болон Өсвөр үе, насны бүлгийн бүх шатны тэмцээн уралдааны амжилт, түүнд хамаарах рекорд амжилтыг тооцохгүй.

5.2. Рекорд амжилт тогтоосон тамирчинд олгох мөнгөн шагналаас бусад бүх мөнгөн урамшууллыг Холбооны хөрөнгөнөөс санхүүжүүлэх бөгөөд ивээн тэтгэгч байгууллага, хувь хүний дэмжлэгийг авч болно.

5.3. Ивээн тэтгэгч байгууллага, хувь хүний дэмжлэгтэйгээр мөнгөн урамшууллын хэмжээг нэмэгдүүлэн олгохыг зөвшөөрнэ.

5.4. Энэхүү журамд заасан нөхцлийг зөрчсөн, ёс зүй болон сахилгын шийтгэл авсан тохиолдолд Холбоо урамшууллыг цуцлах эсвэл буцаан авах эрхтэй.

5.5. Урамшууллын олголтыг жил бүр дүгнэж, шаардлагатай тохиолдолд Холбооны санхүүгийн нөөц боломжид нийцүүлэн нөхцөл, журамд өөрчлөлт оруулж болно.

5.6. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөх бөгөөд журам батлагдахаас өмнөх амжилтад буцаан хэрэглэхгүй.

